

# JET からの手紙

## 青森県今別町とモンゴルフェンシング協会が手をつなぎ 2020年東京オリンピック・パラリンピックを目指す

青森県今別町国際交流員

Sambuudorj OYUNBILIG (サンボードルジ・オユンビリグ)

### 2020年のオリンピック・ パラリンピックは東京にて!

2013年にあるニュースが世界中に発表されました！  
そうです！2020年のオリンピック・パラリンピック（以下、オリパラ）が東京で開催されることが決定しました。



2020年東京オリパラの公式エンブレム

### フェンシングの聖地「今別町」

今別町は青森県におけるフェンシング発祥の地であり、過去にはオリンピック選手を輩出するなど、フェンシング競技が盛んな町です。

その歴史や伝統のもと、ホストタウンの誘致活動を進めた結果、2015年10月に今別町とモンゴルのフェンシング協会は、2020年東京オリパラに向け、モンゴルフェンシングチームの事前合宿を今別町で行う基本合意書を締結しました。

それ以降、年に1回程度モンゴルフェンシング協会の選手たちが今別町で技術を磨くため、強化合宿を実施しています。



今別町で合宿を行うモンゴルフェンシング協会のジュニアチームの選手たち（左から8人目が筆者）

### 今別町“初”の国際交流員として

私は、JETプログラムで来日後、東京での研修が終わり、所属先である今別町へ移動したときの感情や見た景色を今でも鮮明に記憶しています。私を乗せて走る車は、都会の風景を少しずつ後ろに残し、おとぎ話に出てくるような町へと向かっていきました。

右側の車窓からは青々とした海が水平線へと広がり、左側の車窓からは高く伸びる木で生い茂った山が構えており、自然豊かな町だなと思ったことが第一印象でした。

海と山に守られている今別町の人口は2,600人程度であり、今別町にしかない出会いと経験が毎日のように続いています。

私が今別町に着任して2日目で体験したことは「荒馬まつり」です。荒い馬と書いて、津軽方言で「あらま」と呼びます。まつりでは、力強く轟く太鼓の音に、鋭く美しい笛の音色がハーモニーし、そこに鮮やかなねぶたの山車が加わります。ラッセラーのかけ声のもと、荒々しい馬役の男性と手綱を取る女性役がペアとなり、力強く、そして上品に舞います。



毎年8月に開催される荒馬まつり。  
ぜひ一度、今別町にお越し頂き、体験して下さい。

## モンゴル文化講座

私の大好きな仕事の一つはモンゴル文化講座です。毎月2回、今別町の中央公民館でモンゴルについて子どもから大人を対象に紹介しています。

子どもたちと一緒にモンゴルの旗、モンゴルの伝統的な移動式住宅であるゲル、家畜などを描きながら、手作りの絵本を作成しています。子どもたちは一所懸命に絵本を作成しながら、モンゴルについて素朴な質問をしてくれます。モンゴルについていろいろと興味をもってきているなど感じています。このように、地域の子どもたちにモンゴルについて語ることはとても貴重な時間となっています。

大人を対象とした講座では、モンゴルの情勢、都会と遊牧民の生活の違いなどについて具体的に紹介し、自由に話し合い、交流しています。

また、町民の方々と交流し、モンゴルについてもっと



モンゴル民族衣装を着用して楽しむ今別町の方々

### 白いめす馬

出典者 今別町教育委員会 国際交流員 オユンビリグ  
主催 オユンビリグとこどもたちによる「モンゴル文化講座」  
共催 今別町中央公民館 今別町国際交流員 オユンビリグ

今別町中央公民館  
2018年7月13日(金)  
18:00 受付  
18:30 開演  
19:00 エンディング

モンゴル民話朗読会

### 今別町国際交流員の 異文化交流 モンゴル料理

オユンビリグとこどもたちの「モンゴル文化講座」  
第1回モンゴル民話朗読会

モンゴル料理教室

講師: 今別町国際交流員 オユンビリグ  
今別町国際交流員の母ト・メンデルガル  
持ち物: エプロン、三角巾、おにぎり、飲み物  
料金: 無料  
定員: 30人  
申込締切: 1月8日(火)  
主催: 「地域のチカラ結集」モンゴル事業実践  
今別町実行委員会

知ってもらうため、イベントを企画・実施しています。モンゴル民話を日本語へ翻訳したものを朗読したり、モンゴルの伝統料理であるボーズを地域の方々と一緒に作っておいしくいただいたりと、有意義な時間を過ごしています。

イベントの実施にあたり、町民の方々の協力を受けながら実施するため、まさしく、これが草の根レベルの国際交流になっているのではないかと感じています。

## 国際交流員として今別町のために

今別町に来てから、早1年半が過ぎました。国際交流員として今別町にどれだけ貢献できたか振り返ってみると、「まだまだ足りない」という想いです。それと同時に、今後はより一層、今別町民のため、そしてかけがえのない宝である子どもたちのために、もっとモンゴルについて知ってもらいたいという気持ちを強くしています。

### プロフィール



**Sambuudorj OYUNBILIG**  
(サンボードルジ・オユンビリグ)

モンゴル国ウランバートル市出身。両親の仕事の関係で、小学5年生から高校卒業まで大阪在住。モンゴル国立大学にて日本文学を専攻。在モンゴル日本国大使館、JICA勤務後、2017年8月から青森県今別町初のCIRとして勤務中。趣味は日本文学の翻訳、犬の散歩、ロッククライミング。

# JET LETTER

## Аомори мужийн Имабэцү хоттой Монголын туялзуур сэлмийн холбоо гараасаа барилцан 2020 оны Токиогийн Олимпийг зорьж байна

Аомори мужийн Имабэцү хотын Боловсролын газрын Олон улсын харилцааны ажилтан С.Оюунбилиг

### 2020 оны Олимп – Параолимп Токиод хотод болно!

2013 онд нэгэн сайхан мэдээ дэлхий дахинд түгсэн билээ. Тэр бол яах аргагүй 2020 оны зуны Олимп – Параолимпын тэмцээн нь Япон улсын нийслэл Токио хотод зохион байгуулагдах болсон мэдээ юм.

### Туялзуур сэлмийн ариун газар болсон “Имабэцү хот”

Япон улсын Аомори мужийн Имабэцү хот туялзуур сэлмийн муждаа анхлан хөгжүүлсэн хот бөгөөд энэ хотоос Олимпын тэмцээний тамирчин, Японы шигшээ багийн дасгалжуулагч нар төрсөн юм.

### Имабэцү хот болон Монголын туялзуур сэлмийн холбоо 2020 оны Токиогийн Олимпийг угтаж хамтарсан бэлтгэл хийхээр тохиролцсон юм.

Имабэцү хот нь туялзуур сэлмийн түүх уламжлалын дор 2015 оны 10 дугаар сард Монголын туялзуур сэлмийн холбоодын хооронд “2020 оны Токиогийн Олимпт оролцохын тулд Монголын туялзуур сэлмийн холбооны өсвөрийн тамирчдыг Имабэцү хотноо хүлээн авч, урьдчилсан хамтарсан бэлтгэлийг зохион байгуулахаар тохиролцсон гэжээ” байгуулагдсан юм.

Тэр үеэс эхлэн жил бүр Монголын туялзуур сэлмийн холбооны шигшээ багийн тамирчид Имабэцү хотноо ирж, арга барил ур чадвараа улам бататган сайжруулахаар хоёр талын тамирчдын хамтарсан бэлтгэлд оролцох хийгээд уралдаан тэмцээнд амжилттай оролцож ирсэн билээ.

### Имабэцү хотын “Анхны” олон улсын харилцааны ажилтан болов.

Би 2017 оны 8 дугаар сард Токио хотноо 3 хоногийн сургалтанд суугаад амьдарч ажиллах болсон Имабэцү хот руугаа явж байхдаа төрсөн сэтгэгдэл, байгалийн үзэсгэлэнт дүр зургийг одоо хэр нь мартаж чаддаггүй ба надад байнга санагдсаар байдаг юм.

Намайг суулгаад хөдөлсөн машин Аомори хотыг бага багаар ардаа үлдээсээр, үлгэрийн орон шиг энэ үзэсгэлэнт хот руу чиглэсэн юм. Миний сууж явсан машины баруун талын цонхоор урьд өмнө зөндөө үзэж харж байсан ч яг нүдний өмнө цэлэлзэн давалгаалах уяхан цэнхэр хөх далай, зүүн талын цонхоор тэнгэр лүү тэмүүлэх мэт өндөр өндөр ургасан гүн ногоон ой модод ихэмсэгээр танхил найгалдан, бат бөх тариан талбайд энд тэндгүй ирийж, өөрийн эрхгүй “Үзэсгэлэнтэй байгальтай газар байна даа” гэж уулга алдаж, сэтгэл зүрхэнд минь багтаж ядан үлдсэн юм.

Энэ хөлгүй их цэнхэр далай, гүн шигүү ой модод хүрээлүүлэн хамгаалагдаж байгаа Имабэцү хот нь ажилсаг даруухан 2,675 хүн амтай бөгөөд хорвоо ертөнцийн бусад бүх хот тосгодоо болж байдаг учрал, тохиол өдөр бүр цэцгийн дэлбээ мэтээр урган цэцэглэдэгийн адил хорвоогийн олон өнгийг үзүүлсээр байгаа билээ.

Би Имабэцү хотод ирээд хоёр дахь өдрөө л энэ хотын унаган баяр наадам болох алдарт “Догшин морь” гэдэг зуны наадамд оролцсон билээ.

Энэ наадмын нэрийг “Араи буюу Догшин”, “Ума буюу Морь” гэдэг хоёр ханзаар бичиж бас Хойд бүсийн аялагааар “Арама” гэж товчлон дууддаг юм.

Арама наадам нь адуу янцгаах дуу, бөмбөрийн нүргээн, үзэсгэлэн төгс лимбэний аялгууг эгшигтэй хослолдох хийгээд түүн дээр тод өнгийн гоёмсог жууз тэрэг гэрэлтэн нэмэгдэж “Рассэра” гэж нэгэн дуугаар дэмжин хөгжөөх наадамчдын хөг аялгуу дээр догшин морийн дүрд тоглох эрэгтэй, аргамжаа барих дүрд тоглох эмэгтэй хүмүүс нэгэн баг болж хүчирхэг хийгээд уяхан эрхэмсэг бүжгийг даган бүжиглэж цэнгэлдэх баяр юм.

### Монголын соёл уламжлалаас зааж байна.

Миний дуртай ажлын нэг бол Монголын соёлыг танилцуулах хичээл юм.

Би Имабэцү хотын Боловсролын газар дээр сард хоёр удаа буюу нэг удаад хүүхэд багачуудад, дараагийн удаад насанд хүргэгчдэд өөрийн эх орны уламжлал, зан заншил соёлоос танилцуулах хичээл заадаг юм.

Хүүхэд багачуудтай хамтарч монгол орныхоо туг далбааны бэлгэдэл хийгээд түүний утга учир, нүүдэлчин ардын уламжлалт аж ахуй, амьдралын олон талт ёс заншил, орон гэр, таван хошуу мал зэрэг арвин баялаг үүх түүх, аж төрөх ёсноос танилцуулах зорилгын үүднээс хялбархан, ойлгомжтой заахыг эрмэлзэн, хамтдаа зурж будах зэрэг аргаар зурагтай ном хийсэн юм. Энэ ажилд хамтран оролцож буй сурагч багачууд маань хичээнгүйлэн зурагтай ном хийх явцдаа Монгол орны тухай олон янзын асуулт тавьдаг нь тэд эх орны минь тухай ихэд сонирхож буйн шинж гэсэн сэтгэгдэл төрүүлдэг юм.

Ийнхүү Имабэцү хотынхоо хүүхэд багачуудтай манай орны талаар ярилцаж байхдаа сурагчдын боловсрол мэдлэгт өчүүхэн ч гэсэн хувь нэмрээ оруулж буйгаа ухаардаг ба миний хувьд энэ цаг хугацаа ямар ч үнэ цэнээр олдохгүй сайхан цаг болж өнгөрдөг юм.

Насанд хүрэгчдийн ангийн сурагчидтайгаа манай улсын өнөөгийн байдал, хот хөдөөгийн ялгаа, хүмүүсийн амьдралын өөрчлөгдөн хувирч буй олон талын өнгө зэрэг илүү гүнзгий сэдвээр дэлгэрэнгүй ярилцаж чөлөөтэйгээр санал бодлоо хуваалцаж байна.

### Бие даасан төсөл төлөвлөж, зохион байгуулаж байна.

Миний хувьд Имабэцү хотын ард иргэдтэй холбосон харилцаагаа илүү дотно болгохын тулд эх орныхоо тухай илүү дэлгэрэнгүй танилцуулж, тэдний мэдлэгт дусал боловч нэмэрлэхсэн гэж бодож явдаг иргэний хувьд бие даасан төсөл төлөвлөн боловсруулж байна.

Тэр ажлын хүрээнд монгол ардын “Цуутын цагаан гүү” гэх үлгэрийг япон хэлнээ хөрвүүлж, уран уншлага болгон хувиргаж нэгэн зуны оройг хотын ард иргэдтэй өнгөрүүлсэн юм. Мөн түүнчлэн үндэснийхээ хоол болох буузыг хотын иргэдтэй хамтран хийж, амтархан идэж үнэлж барамгүй нэгэн өдрийг өнгөрөөсөн билээ.

### Имабэцү хотын “Анхны” олон улсын харилцааны ажилтны хувьд Имабэцү хотын хөгжилд хэрхэн хувь нэмэр оруулсан бол?

Би Имабэцү хотноо ирж амьдарч ажиллаад хэдийн жил хагасын ардаа үдсэн авч “Би энэ хугацаанд олон улсын харилцааны ажилтны хувьд Имабэцү хотдоо өөрийн хувь нэмэр оруулж чадсан болов уу?” гэж өөрөөсөө асуухад “Хангалттай биш байна” гэсэн хариулт л бодогдож байна.

Тиймээс цаашид Имабэцү хотын иргэдийн тусын тулд, юугаар ч сольшгүй эрдэнэ болсон хүүхэд багачуудад өөрийн эх орныхоо талаар илүү сайхан бас илүү их мэдлэгтэй болгохын тулд хичээнгүйлэн чармайж ажиллах бодолтой байна.

### Profile

Монгол улсын Улаанбаатар хотод төрсөн. Бага сургуулийн тав дугаар ангиас ахлах сургууль төгсгөх хүртэл Осакад амьдарч суралцан, МУИС-ийг Япон судлаачаар төгсгөсөн. Монгол дахь Япон улсын Элчин сайдын яам, JICA-гийн Монгол дахь салбарын ажилтан байсан ба өдгөө Аомори мужийн Имабэцү хотын анхны Олон улсын харилцааны ажилтнаар сонгогдон ажиллаж байна. Японы уран зохиолоос эх хэл дээрээ орчуулах, нохойтойгоо уулар алхах, хадны авиралт хийх хоббитой.

モンゴル語